



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 1/180

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. БНХАУ-ын Хөх хотод суугаа ерөнхий консулын газар, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Гадаад хэрэг эрхлэх газар болон БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн ажил мэргэжлийн дээд сургуультай хийсэн мэргэжлийн ур чадварын сургалтыг хөгжүүлэх тухай гурван талт хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу 2017 оны 5 дугаар сарын 14-нөөс 16-ны өдрүүдэд сургалтад хамрагдах 30-н хүнийг хүргэж өгөхөөр аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Ганбаатараар ахлуулсан албаны төлөөлөгчид БНХАУ-ын Шилийн гол аймаг явахад 2015300 /хоёр сая арван таван мянга гурван зуун/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Зардлын тооцоо

№	Зардал		Хүн	Нэгж	Үнэ	Нийт
1	Томилолт		3 хүн	5 хоног	35500	532500
2	Тулш	/Чингис-Замын	1200 км	216 л	1800	388800
3	Бензин А92	Үүд-Чингис/		240 л	1700	408000
3	Зураг			1ш	120000	120000
4	Бэлэг дурсгал	Гарын бэлэг		10ш	15000	150000
5		Бэлэгний уут		10ш	1600	16000
6	Хүнс					400000
ДҮН						2015300